



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1/15

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай Г

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1 Төр захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх үйлсэд хамт олноо тэргүүлэн ажиллаж буй Чандмань сумын Засаг даргын орлогч З.Онолбаатар, татварын байцаагч Ю.Нямтулга нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан З.Онолбаатар, Ю.Нямтулга нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Чандмань сумын Засаг дарга /Б.Галбадрах/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.00150

D/Zax-A/15-Da